Батлав:

Ерөнхий инженер ...../Д.Отгонбаяр/

Цахилгаан эрчим хүчээр хангах техникийн нөхцөл: Дугаар № 60/ 2020

2020 оны 04-р сарын 28 - ны өдөр

Мөрөн сум

1. **Техникийн нөхцөл хүссэн хэрэглэгчийн нэр**: Монгол улсын Эрчим хүчний сайд Ц.Даваасүрэн, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, Чингисийн өргөн чөлөө, ЗГ-ын XIV байр, Утас. 51-263051
2. **Хэрэглэгчийн байршил:** Хөвсгөл аймаг, Чандмань-Өндөр сумын төвд гэр хорооллын айл өрхийн цахилгаан хангамжийн техникийн боломжийг сайжруулах
3. **Техникийн нөхцөл олгох үндэслэл:** Монгол улсын Эрчим хүчний сайд Ц.Даваасүрэнгийн 2020 – 04-24-ны өдрийн № а/ 1345 тоотын дагуу
4. **Техникийн даалгавар**: Чандмань-Өндөр сум
   1. АТП-3 дэд өртөөний порталаас салбарлалт авч, 10 кВ-ын 900 метр төмөр бетонон тулгууртай АС-50 дамжуулагч утастай ЦДАШ татаж, 10/0,4 кВ-ын 160 кВа хүчин чадалтай, эрчим хүчний хэмнэлттэй аморф зүрхэвчтэй дэд өртөө барих, 0,4 кВ-ын төмөр бетонон тулгууртай СИП-50 утастай магистраль шугам – 1150 метр, төмөр бетонон тулгууртай СИП-35 утастай салбар шугам - 1600 метр татан, 6 ширхэг тоолуурын багтаамж бүхий тоолуургүй щит - 14 ширхэгийг бүрэн тоноглож суурилуулах
   2. АТП-3 дэд өртөөнөөс 0,4 кВ-ын нэмэот гаргалга шинээр гарган төмөрбетонон тулгууртай СИП-50 утастай шугам – 450 метрийг шинээр татах
5. **Тоолуур :** /DTYZ-88 бүхий бүрэн электрон тоолуур/
6. **Гүйдлийн трансформатор:** тооцоогоор сонгох
7. **Тусгай заалтууд**: (Энэ дэд өртөө шугамыг өргөтгөх,шугамын трасс өөрчлөх, гадны хэрэглэгчийн шугамаас тэжээхэд тавигдах шаардлага болон шаардлагатай бусад заалтууд орно).
8. **Техникийн нөхцлийн хүчинтэй хугацаа:** 1 жил
9. **Щит тоноглолын болон газардуулгыг норм дүрэм стандартын дагуу хийх.** / Зайлшгүй газардуулга хийж хангагч байгууллагын эрх бүхий ажилтнаар хэмжүүлж акт гаргуулж авах шаардлагатай/

Дор дурьдсан техникийн даалгавар, хууль, дүрмийг мөрдөх:

Дээр өгөгдсөн холболт хийх цэгээс холбогдох дүрэм зааврын дагуу шугам татан авч, тоног төхөөрөмжийн газардуулгыг норм стандартын дагуу хийн эрх бүхий байгууллагаар хэмжүүлэн акт гаргуулан авах

Кабель шугамын трасс, хамгаалалтын зурваст барилга барих, зам талбай засах, бетондохыг хориглоно.

Цахилгаан угсралтын ажлыг тусгай зөвшөөрөлтэй мэргэжлийн байгууллагаар цахилгаан техникийн байгууламжийн дүрэм , аюулгүй ажиллагааны дүрэм , техник ашиглалтын дүрмийн дагуу гүйцэтгүүлэх.

Хүчдэлийн түвшингийн ±5%-ийн хэлбэлзэлд зохицсон тоноглол суурилуулах.

Засгийн газрын 2001 оны өдрийн 263 тоот тогтоолоор батлагдсан "Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм"-ийн заалтыг мөрдлөгө болгох.

Хэрэглэгч нь өөрийн эзэмшлийн цахилгаан тоног төхөөрөмжийн ашиглалт үйлчилгээний зааг доторхи цахилгаан тоног төхөөрөмжийн ашиглалт, аюулгүй ажиллагааг хариуцсан ажилтныг томилох бөгөөд шугам сүлжээний хамгаалалтын зурвас дотор гэр , орон сууц, барилга байгууламж барих, шугам сүлжээ өмчлөгч, эзэмшигчийн зөвшөөрснөөс бусад үйл ажиллагаа явуулахыг хориглоно. (Хэвийн бус үйл ажиллагаатай үед өөрсдийн хөрөнгөөр засвар үйлчилгээ хийлгэх)

Энэхүү техникийн нөхцөлийн дагуу холболтыг 1 жилийн хугацаанд хийж гүйцэтгэх бөгөөд энэ хугацаанд цахилгаан сүлжээнд холбогдоогүй тохиолдолд шинээр техникийн нөхцөл авна.

Цахилгаан эрчим хүчний тооцоог сар бүрийн 20 -ны дотор хийх.Хэрэглэгч нь Эрчим хүчний тухай хуулийн 30.1.11-д заасны дагуу хүчин чадлын хүрээнд тус компанийн зөвшөөрлөөр шинээр хэрэглээг нэмэх бол зөвшөөрөл авч холбуулах үүрэгтэй.

Техникийн комиссын гишүүд:

Ашиглалтын хэсгийн ахлах инженер.....Г.Даваадорж

ДРХТТ-ын хэсгийн инженер.....Б.Хишигбаатар

ГТХэмнэлтийн инженер..... Ч.Бямбабаяр

Хяналтын инженер..... Э.Өнөболд